



**ОРЛОГО БА ХӨРӨНГИЙН ТАТВАРЫГ ДАВХАРДУУЛЖ
НОГДУУЛАХГҮЙ БАЙХ, ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ЯВДЛААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН КОНВЕНЦ**

Тус хоёр улсын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилгоор орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Конвенц байгуулахаар шийдвэрлэж, Монгол Улсын Засгийн газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газар дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл. Хамаарагдах этгээд

Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу эдгээрийн аль нэгийг нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамаарна.

2 дугаар зүйл. Хамаарагдах татварууд

1. Хэлэлцэн тохирогч Улсын орлого ба хөрөнгөд ногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн ногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү Конвенцид хамаарна.

2. Орлого ба хөрөнгөд ногдуулж буй татвар гэж нийт орлого буюу нийт хөрөнгө болон орлого буюу хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэгт ногдуулж буй бүх төрлийн татвар, түүний дотор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого, аж ахуйн нэгжийн цалин хөлсний нийт хэмжээ болон хөрөнгийн үнэлгээний өсөлтийн орлогод ногдуулж буй татварыг хэлнэ.

3. Энэхүү Конвенцид дараахь татварууд хамаарагдана:

a/ Монгол Улсын хувьд:

aa/ хүү амын орлогын албан татвар,

bb/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар.

/цаашид "Монголын татвар" гэнэ/

b/ Нэгдсэн Вант Улсын хувьд:

aa/ орлогын татвар,

bb/ корпорацийн татвар, болон

vv/ хөрөнгө борлуулсны татвар.

/Цаашид "Нэгдсэн Вант Улсын татвар" гэнэ/

4. Энэхүү Конвенцид гарын үсэг зурсан өдрөөс хойш шинээр бий болсон, одоогийн татварт нэмэлт болох буюу тэдгээрийг орлох татварууд нь 3 дугаар заалтад дурдсан татваруудтай адил буюу төстэй байвал энэхүү Конвенцид мөн хамаарагдана. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллага нь өөрийн орны татварын хуульд орсон аливаа зарчмын өөрчлөлтийн талаар нөгөө талдаа өөрчлөлт орсноос хойш тодорхой хугацаанд мэдэгдэж байна.

3 дугаар зүйл. Ерөнхий тодорхойлолт

1. Энэхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол:

а/ "Монгол Улс" гэж газар зүйн утгаараа авч үзвэл Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хэлнэ.

б/ "Нэгдсэн Вант Улс" гэж олон улсын хуулийн дагуу тогтоосон буюу тогтоож болох Нэгдсэн Вант Улсын хилийн усны гаднах аливаа нутаг дэвсгэрийг оролцуулан Их Британи, Умард Ирланд болон Нэгдсэн Вант Улсын тивийн эргийн орчмын нутаг, мөн түүнчлэн Нэгдсэн Вант Улсын байгалийн ноодийг нь ашиглах эрх бүхий далайн ёроол ба газрын хэвлийг хэлнэ.

в/ "Харьяат" гэж

1. Нэгдсэн Вант Улсын хувьд Британий харьяатын эрх эдхлэг Британий харьяат буюу Хамтын Нийгэмлэгийн аливаа улсын, эсвэл нутаг дэвсгэрийн харьяат бус Британий харьяат болон Нэгдсэн Вант Улсын хүчин төгөлдөр хуулийн дагуу эрх бүхий аливаа хуулийн этгээд, партнершин /нөхөрлөл/, нэгтгэл буюу бусад этгээд.

2. Монгол Улсын хувьд Монгол Улсын харьяат аливаа хувь этгээд болон Монгол Улсад хүчин төгөлдөр хуулийн дагуу эрх бүхий аливаа хуулийн этгээд, партнершин /нөхөрлөл/ буюу нэгтгэл.

г/ "Хэлэлцэн тохирогч Улс" болон "Хэлэлцэн тохирогч нөгөө Улс" гэж тухайн заалтын утгаас хамааран Монгол Улс буюу Нэгдсэн Вант Улсыг хэлнэ.

д/ "Этгээд" гэж хувь этгээд, компани болон энэхүү зүйлийн 2 дугаар заалтад дурдсан партнершинээс /нөхөрлөл/ бусад бүлэг этгээдийг хэлнэ.

е/ "Компани" гэж хуулийн эрх бүхий аливаа этгээд буюу татвар ногдуулах утгаараа түүнтэй адилтгах аливаа байгууллагыг хэлнэ.

ж/ "Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж" гэж тухайн энэ улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ. "Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж" гэж тухайн нөгөө Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ.

з/ "Олон улсын тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжээс хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслээр хийх аливаа тээврийн үйл ажиллагааг хэлнэ. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө Улс доторх байрлалуудын хооронд хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслээр хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна.

и/ "Эрх бүхий этгээд" гэж Монгол Улсын хувьд Сангийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгч, болон Нэгдсэн Вант Улсын хувьд Дотоодын орлогын Комиссарууд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ.

2. Монголын хуулийн дагуу татвар төлбөл зохих нэгж боллог партнершиныг /нөхөрлөл/ энэхүү Конвенцийн хувьд этгээд гэж үзнэ.

3. Хэрэв энэхүү Конвенцийн аливаа заалтын дагуу партнершин /нөхөрлөл/ нь Нэгдсэн Вант Улсын аливаа орлогын буюу хөрөнго

борлуулснаас олсон орлогын татвараас Монголын байнга оршин суугчийн хувьд чөлөөлөгдөөч, тэрхүү орлого буюу хөрөнгө борлуулснаас олсон орлогын Нэгдсэн Вант Улсын байнга оршин суугч партнершипын /нөхөрлөл/ гишүүний хувьд олсон хэсэгт Нэгдсэн Вант Улсын татвар ногдуулах эрхийг энэхүү заалтаар хязгаарлаж байна гэсэн үг бишээ, гэхдээ аливаа ийм орлого буюу хөрөнгө борлуулсны орлогыг энэхүү Конвенцийн 24 дүгээр зүйлийн хувьд Монголд бий болсон орлого буюу хөрөнгө борлуулсны орлого гэж үзнэ.

4. Энэхүү Конвенцид тодорхойлогдоогүй аливаа нэр томъёог Конвенцид өөрөөр заагаагүй бол Конвенциор зохицуулагдаж буй татвартай холбогдол бүхий Хэлэлцэн тохирогч Улсын дотоодын хуульд зааснаар ойлгоно.

4 дүгээр зүйл. Байнга оршин суудаг газар

1. Энэхүү Конвенцид "Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад байнга оршин суугч гэж өөрөө голлох удирдлага болон аж ахуйн нэгжээ бүртгүүлсэн газар нь байнга оршин сууж, байрлаж байгаа, мөн үүнтэй адилтгах бусад шалтгаанаар оршин сууж, байрлаж тэр Улсын хуулийн дагуу тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ. Гэвч энэ нь тухайн Улс дахь эх үүсвэрээ олсон орлого ба тэнд оршдог хөрөнгөөс олсон орлогод тухайн Улсад татвар төлөх ёстой аливаа этгээдийг хамаарахгүй.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль алинд нь байнга оршин суугч хувь этгээдийн статусыг дараахь байдлаар тодорхойлно.

а/ Байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа /язгуур эрх ашгийн төв/ нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно.

б/ Хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий Улсыг тодорхойлох аргагүй, эсвэл энэ хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түр орогнох байртай байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

в/ Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь түр орогнох байртай, эсвэл алинд нь ч байхгүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль Улсын харьяат байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно.

г/ Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины харьяат эсвэл алиных нь ч харьяат биш бол асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу компани нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины нь байнга оршин суугч бол голлох удирдлага нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

5 дугаар зүйл. Төлөөлөгчийн газар

1. Энэхүү Конвенцид "Төлөөлөгчийн газар" гэж аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэглэн явуулдаг байнгын байрлалыг хэлнэ.

2. "Төлөөлөгчийн газар" гэдэгт тухайлбал:

- а/ Аж ахуйг удирдан явуулж буй газар,
- б/ Салбар байгууллага,
- в/ Албан байгууллага,
- г/ Үйлдвэр,
- д/ Цех болон,

е/ Уурхай, газрын тос буюу байгалийн хий ашиглах цооног, ил уурхай болон байгалийн бусад ашигт малтмал олборлож буй газар орно.

3. Зөвхөн 12 сараас дээш хугацаагаар үргэлжлэх барилгын талбай, барилга буюу угсралтын ажлыг төлөөлөгчийн газар гэж тооцно.

4. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад дурдсан "Төлөөлөгчийн газар" гэдэгт дараахь үйл ажиллагаа үл хамаарна:

а/ Аж ахуйн нэгж зөвхөн өөрийн бараа, эд агуурсыг хадгалах, үзэжлэнд тавих, нийлүүлэх зорилгоор аливаа байгууламж ашиглах.

б/ Аж ахуйн нэгж зөвхөн хадгалах, үзэжлэнд тавих зорилгоор өөрийн бараа, эд агуурс байлгах.

в/ Аж ахуйн нэгж зөвхөн өөр бусад аж ахуйн нэгжээр боловсруулалт хийлгэх зорилгоор бараа, эд агуурс байлгах.

г/ Аж ахуйн нэгж өөртөө зориулан бараа, эд агуурс зөвхөн худалдан авах буюу мэдээлэл цуглуулах зориулалтаар байнгын байрлал байлгах.

д/ Аж ахуйн нэгж өөртөө зориулан бэлтгэх, туслах чанарын аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор зөвхөн байнгын байрлал байлгах.

е/ Байнгын байрлалын нийт үйл ажиллагаа нь бэлтгэх буюу туслах чанарын хоршсон үйл ажиллагаанаас бүрдсэн тохиолдолд а -д дурдсан үйл ажиллагааны төрлүүдийг аливаа байдлаар нэгтгэн үйл ажиллагаа явуулах зорилгоор зөвхөн байнгын байрлал байлгах.

5. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан 6 дугаар заалтад хамаарах бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч Улсад аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж гэрээ /контракт/ байгуулах эрх эгэлдэг бол уг аж ахуйн нэгжийг өөрийн тусам тулд явуулж буй аливаа үйл ажиллагааны хувьд нь Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газартай гэж үзнэ. Гэхдээ уг этгээдийн үйл ажиллагаа 4 дүгээр заалтад дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдан, хэрэв энэхүү үйл ажиллагаа байнгын байрлалаар дамжин явагдаж байвал уг байнгын байрлалыг энэхүү заалтын дагуу төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

6. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг брокер, сроңхий комиссын төлөөлөгч, бие даасан эрх бүхий бусад төлөөлөгчдөөр дамжуулан

үйл ажиллагаа явуулж байгаа бол түүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газартай гэж үзэх үндэс болохгүй бөгөөд тэдгээр этгээд нь өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байх нь үүний нөхцөл болно. Гэхдээ ийм төлөөлөгчийн үйл ажиллагаа нь бүхэлдээ буюу дийлэнхдээ уг аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс хийгдэж, аж ахуйн нэгж, төлөөлөгчийн хоорондын үйл ажиллагаа нь ердийн хэм хэмжээнээс өөрөөр хийгдсэн тохиолдолд энэхүү заалтын хүрээнд ийм төлөөлөгч нь бие даасан эрх бүхий төлөөлөгч гэж тооцогдохгүй.

7. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршдог эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаагаа төлөөлөгчийн газраар дамжуулах буюу бусад аргаар явуулдаг компанийг хянадаг эсвэл хяналтанд байдаг нь эдгээр компанийг бие биеийнх нь төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

6 дугаар зүйл. Үл хөдлөх хөрөнгөнөөс орох орлого

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөнөөс Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн олсон орлогод түүний дотор хөдөө аж ахуй буюу ойн аж ахуйгаас олсон орлого\ Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Үл хөдлөх хөрөнгө" гэсэн нэр томъёог тухайн хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улсын хуульд зааснаар ойлгоно. Аль ч тохиолдолд уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөд дагалдах өмч, хөдөө аж ахуйд ашиглагдаж буй мал амьтан, тоног төхөөрөмж, газар оролцсон өмчийн талаархи хуулийн заалтыг хэрэглэх эрх, ашигт малтмалын орд, рашаан ус болон байгалийн бусад баялгийг ашиглах буюу ашиглахын төлөө байнгын буюу байнгын бус төлбөрийн эрхийг багтаана. Харин хөлөг онгоц, нисэх онгоц, төмөр болон хуурай замын тээврийн хэрэгсэл үл хөдлөх хөрөнгөд орохгүй.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь үл хөдлөх хөрөнгийг шууд ашиглах, бусад түрээслүүлэх, эсвэл бусад аль ч хэлбэрээр ашиглах замаар олсон орлогод мөн хамаарна.

4. Энэхүү зүйлийн 1 ба 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээнд ашигласан үл хөдлөх хөрөнгөнөөс олсон орлогод хамаарна.

7 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан үйл ажиллагааг төлөөлөгчийн газраар дамжуулан эрхлэхэд уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн төлөөлөгчийн газарт хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харьцан адил, эсвэл төстэй үйл ажиллагаа, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс бүрт тооцно.



3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлохдоо төлөөлөгчийн газар оршиж байгаа Хэтэлцэн тохирогч Улс болон бусад Улсад тус төлөөлөгчийн газар өөрийн зорилгоо хэрэгжүүлэхэд гаргасан зардлууд, мөн түүнчлэн аж ахуйн нэгжийн нь хувьд бүхэлд нь авч үзвэл түүнээ зарцуулсан удирдлагын болон ердийн захиргааны зардлын хэвийн зарцуулалтыг тооцно.

4. Хэтэлцэн тохирогч Улсад түүний хуулийн дагуу аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт орлогыг тэгшитгэн хуваарилдаг хэвшсэн аргаар төлөөлөгчийн газарт ногдох ашгийг хуваадаг бол тэр улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход 2 дугаар заалт саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэ зүйлийн зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохино.

5. Аж ахуйн нэгж нь төлөөлөгчийн газраар дамжуулан бараа, эд агуурыг зөвхөн худалдан авдаг бол үүнийг үндэслэн уг төлөөлөгчийн газрыг ашиг олсонд тооцож үл болно.

6. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад нийцүүдэн төлөөлөгчийн газарт хамаарах ашгийг тодорхойлох аргыг өөрчлөх баттай үндэслэлгүй бол жинтээ жилд тогтсон нэг арга хэрэглэнэ.

7. Хэрэв ашиг нь энэхүү Конвенцийн бусад зүйлд тусгайлан тодорхойлсон орлогын төрлийг агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

8 дугаар зүйл. Олон улсын тээвэр

1. Олон улсын шугамд хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэр хийж олж байгаа Хэтэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн ашигт зөвхөн Хэтэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

2. Энэхүү зүйлд заасан хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслийн үйл ажиллагааны ашигт дараах зүйлийг оруулна:

а/ Хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслийг баггүй түрээслэсний орлого, болон

б/ Бараа эд агуурс тээвэрлэхэд ашигласан чингэлгийг хэрэглэсэн, хэвийн ажиллагаанд байлгасан буюу түрээслэсний /чингэлгийг тээвэрлэхтэй холбогдол бүхий тоног төхөөрөмж болон чиргүүлийг оролцуулан/ ашиг.

Ийм түрээс буюу ийм ашиглалт, хэвийн ажиллагаанд байлгах буюу түрээс нь олон улсын шугамд ашиглаж байгаа хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай замын тээврийн хэрэгслийн туслах чанарын хэрэглээ байж болно.

3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтууд нь пул, хамтарсан үйлдвэр болон олон улсын тээврийн ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна. Гэхдээ энэхүү хамтын ажиллагаанд оруулсан өөрийн хувь хэмжээний хэрээр олсон ногдох ашигт л хамаарна.

9 дүгээр зүйл. Харьга аж ахуйн нэгжүүд

1. Хэрэв:

а/ Хэтэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэтэлцэн тохирогч ногоо Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд болон шууд



бусаар оролцдог бол, эсвэл

б/ Тухайн этгэдүүд Хэтэлцэн тохирогч Улсын болон Хэтэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт буюу хөрөнгөнд шууд буюу шууд бусаар оролцдог бол,

Тэдгээр хоёр нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцөлөөс ялгаатай бөгөөд дээрх ялгаатай нөхцөлийн улмаас тухайн аж ахуйн нэгжид ногдох ёстой ашиг тооцогдоогүй байвал Хэтэлцэн тохирогч Улс уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан тооцож зохих журмын дагуу татвар ногдуулж болно.

2. Хоёр аж ахуйн нэгжийн хоорондын харилцаа нь бие даасан аж ахуйн нэгжийн хоорондын харилцааны нөхцөлтэй нийцж байх тохиолдолд Хэтэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжээ өөрийн Улсаа татвар төлөх ёстой ашигийг эхэнд дурдсан Улс өөрийн ашиг гэж тооцон өөрийн аж ахуйн нэгжийн ашигт оруулан татвар ногдуулсан байвал нөгөө Улс зохицуулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэхүү ашгаас авах татварын хэмжээнд холбогдох зохицуулалт хийнэ. Ийм зохицуулалтыг хийхдээ энэхүү Конвенцийн бусад заалтуудыг харгалзан үзэх бөгөөд Хэтэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд шаардлагатай гэж үзвэл харилцан зөвлөлдөж болно.

10 дугаар зүйл. Дивиденд

1. Хэтэлцэн тохирогч Улсад байнга оршдог компаниас Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршигч этгээдэд төлж буй дивидендэд Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ дивиденд төлж буй компани байнга оршдог Хэтэлцэн тохирогч Улсад тухайн дивидендэд өөрийн хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч дивиденд авагч нь түүний жинхэнэ эзэмшигч бол ногдуулах татварын хэмжээ нь дор зааснаас хэтрэхгүй:

а/ Дивидендийг жинхэнэ эзэмшигч нь компани бөгөөд тэрээр дивиденд төлж байгаа компаний санхүүгийн 10-аас доошгүй хувийг шууд буюу шууд бусаар эзэмшиж байгаа бол дивидендийн нийт дүнгийн 5 хувиас,

б/ Бусад бүх тохиолдолд дивидендийн нийт дүнгийн 15 хувиас.

Энэхүү заалт нь тухайн компаний дивиденд агуулсан орлогог ногдуулах татварт үл хамаарна.

3. Энэхүү зүйлд тусгагдсан "Дивиденд" гэсэн нэр төмбөгөнд хувьцааны ногдол ашиг болон өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр оролцох эрхээ үүсэх орлого, мөн түүнчлэн хуваарилалт хийж буй компаний байнга оршин суудаг Хэтэлцэн тохирогч Улсын татварын хуулинд заасан хувьцааны ногдол ашигтай адилтгах аж ахуйн бусад эрхээ үүсэх орлого болон дивиденд төлж байгаа компаний байнга оршин суудаг Хэтэлцэн тохирогч Улсын хуулинд заасан /энэхүү Конвенцийн 11 дүгээр зүйлд зааснаар хөнгөлөгдсөн хүүтгээ бусад/ аливаа бусад орлогыг компаний дивиденд буюу компаний хувь хүртэгчийн орлого гэж үзэж хамаарагдана.

4. Хэрэн дивидендийн эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэтэлцэн тохирогч Улсад байнга оршдог бөгөөд дивиденд гологч компани байрладаг нөгөө

Улсад төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг төвлөсөн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг ба дивидендийн эрх хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу төвлөсөн газарт шууд хамааралтай бол 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд энэхүү Конвенцийн 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал нөгөө Улс уг компаний төлж буй дивидендэн татвар ногдуулж болохгүй. Мөн дивиденд нь хуваарилагдаагүй ашгаас төлөгдөж байлаа ч гэсэн, хуваарилагдаагүй ашиг бүхэлдээ буюу хэсэгчлэн нөгөө Улсад бий болсон ашиг, орлогоос бүрэлдэж байлаа ч гэсэн компаний хуваарилагдаагүй ашигт татвар ногдуулж болохгүй. Гэхдээ уг компаниас нөгөө Улсад байнга оршин суугчид төлж байгаа дивиденд буюу дивиденд авах эрх нь нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар ба төвлөсөн газартай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно.

6. Хэрэв энэхүү зүйлийн дивиденд төлөгдөх илүү талыг ашиглах зорилгоор аливаа этгээд нь гол зорилго буюу гол зорилгуудын нэг болгон өөрийн хувьцаа буюу бусад эрхийг бий болгосон буюу байршуулсан бол энэхүү зүйлийн заалтуудыг хэрэглэхгүй.

11 дүгээр зүйл. Хүү

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ хүү бий болсон Хэлэлцэн тохирогч Улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч, хэрэв уг хүүг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ногдуулах татварын хэмжээ хүүгийн нийт дүнгийн 10 хувиас хэтэрч болохгүй.

3. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан уг хүүг хүлээн авагч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын банкны үйл ажиллагааг бодитоор эрхэлдэг банк бөгөөд хүүг жинхэнэ эзэмшигч мөн бол Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон хүүд Хэлэлцэн тохирогч Улсад ногдуулах татварын хэмжээ хүүгийн нийт дүнгийн 7 хувиас хэтэрч болохгүй.

4. Энэхүү зүйлд тусгагдаж буй "Хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, эзэлдэгчийн орлогод оролцох эрхтэй эсхийг үл харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн эсхийг үл харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого, ялангуяа улсын сангийн орлого, эзлэлэг бусад үнэт цааснаас орох орлого, мөн тэдгээрийн урамшууллын орлого орно. "Хүү" гэдэг нэр томъёо нь 10 дугаар зүйлийн дагуу дивиденд гэж үзсэн орлогын хэсгүүдийг үл хамаарна.

5. Хэрэв хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог төвлөсөн газраас мэргэжлийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь дурдсан төлөөлөгчийн газар буюу төвлөсөн газартай шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1,2,3,12 ба 13 дугаар заалтыг мөрдлөг болгохгүй. Энэ тохиолдолд энэхүү Конвенцийн 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

6. Хүү төлөгч нь Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу тэр Улсын байнга оршин суугч бол, хүүг Хэлэлцэн тохирогч Улсад

бий болсон гэж үзнэ. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эрхийг үл харгалзан, хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл товлосон газарт бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газар оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад хүүг бий болсон гэж үзнэ.

7. Хэрэв хүү төлөгч болон хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигчдийн хооронд, мөн түүнчлэн тэдгээрийн аль нэг гуравлагч этгээдийн хооронд тогтоосон онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал, энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан эцэст дурдсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

8. Хэлэлцэн тохирогч Улсуудын хуулийн аливаа заалт нь байнга оршин суугч бус компанид төлсөн хүүтэй зөвхөн холбоотой бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч компанид төлсөн хүүг тэрхүү хүүг төлж байгаа компаний хувьд дивиденд буюу хувь хүртэгчийн орлого гэж үзэхгүй. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч этгээд буюу этгээдүүд Хэлэлцэн тохирогч Улсуудын аль нэгний байнга оршин суугч компаний саналын 50-наас илүү хувийг шууд буюу шууд бусаар эзэмшдэг бол уг компанид төлсөн хүүд өмнөх өгүүлбэр үл хамаарна.

9. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтад дурдсан татварын хөнгөлөлтийг хүүг жинхэнэ эзэмшигчийн хувьд дараах нөхцөлд хэрэглэхгүй.

а/ Байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улсад нь уг орлого татвараас чөлөөлөгддөг бол, болон

б/ Өрийн нэхэмжлэлийг худалдан авснаасаа хойш гурван сарын дотор түүнээс олох хүүгийн хамт худалдах гэрээ хийсэн буюу худалдсан бол.

10. Хэрэв энэхүү зүйлийн хүү төлөгдөх илүү талыг ашиглах зорилгоор аливаа этгээд нь гол зорилго буюу гол зорилгуудын нэг болгон өөрийн өрийн нэхэмжлэлийг бий болгосон буюу байршуулсан бол энэхүү зүйлийн заалтуудыг хэрэглэхгүй.

11. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын Засгийн газар, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хүүг жинхэнээр эзэмшиж, хүүг авч байвал Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон хүүг тэр Улсад татвараас чөлөөлнө.

12. Энэхүү зүйлийн 2 ба 3 дугаар заалтуудыг үл харгалзан Нэгдсэн Вант Улсын Экспортын Зээлийн Баталгааны Газраар баталгаажуулсан буюу даатгуулсан зээл буюу аливаа бусад өрийн нэхэмжлэл болон өгсөн, баталгаажуулсан буюу даатгуулсан зээлийн хувьд хүү төлөгдсөн бол Монгол Улсад бий болж, жинхэнээр эзэмшдэг Нэгдсэн Вант Улсын байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүг Монгол Улсад татвараас чөлөөлнө.

13. Энэхүү зүйлийн 2 ба 3 дугаар заалтуудыг үл харгалзан Монгол Улсын Худалдаа хөгжлийн банкаар баталгаажуулсан буюу даатгуулсан зээл буюу аливаа бусад өрийн нэхэмжлэл болон өгсөн, баталгаажуулсан буюу

даатгуулсан эзэнийн хувьд хүү төлөгдсөн бол Нэгдсэн Вант Улсад бий болж, жинхэнээр эгэмшдэг Монгол Улсын байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүт Нэгдсэн Вант Улсад татвараас чөлөөлно.

12 дугаар зүйл. Эрхийн шимтгэл, шан харамж

1. Хэтэлцэн тохирогч Улсад бий болж, Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй эрхийн шимтгэл, шан харамжад нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ Хэтэлцэн тохирогч Улсад бий болж байгаа эрхийн шимтгэл, шан харамжад тухайн Улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч, хэрэв уг эрхийн шимтгэл, шан харамжийн хүлээн авагч нь түүний жинхэнэ эгэмшигч мөн бол ийнхүү ногдуулж байгаа татвар нь эрхийн шимтгэл, шан харамжийн нийт дүнгийн 5 хувиас хэтэрч болохгүй.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй “Эрхийн шимтгэл, шан харамж” гэсэн нэр томъёонд, аливаа зохиогчийн эрх, урлаг буюу шинжлэх ухааны бүтээл /уран сайхны кино болон радио буюу телевизийн нэвтрүүлэгт зориулсан кино буюу бичлэгийг оролцуулан/, аливаа патент, барааны гэмдэг, зураг төсөл буюу загвар, төлөвлөгөө, нууц томъёонол буюу арга ажиллагааг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн, эсвэл үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны салбарт олсон арга туршилтаатай /ноу-хау/ холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөрийг хамааруулна.

4. Хэрэв эрхийн шимтгэл, шан харамж жинхэнэ эгэмшигч нь Хэтэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэтэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулагч бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа, эсвэл Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог төвлөсөн газраар дамжуулан мэргэжлийн бие даасан хувийн үйлчилгээ хийдэг, түүнчлэн эрхийн шимтгэл, шан харамж авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг хэрэглэхгүй. Энэ тохиолдолд энэхүү Конвенцийн 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Эрхийн шимтгэл, шан харамж төлөгч нь Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу тэр Улсын байнга оршин суугч бол уг эрхийн шимтгэл, шан харамж Хэтэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Гэхдээ Хэтэлцэн тохирогч Улсад байнга оршин суудаг эсхийг үл харгалзан эрхийн шимтгэл, шан харамж төлөгч этгээд уг Хэтэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газраар дамжуулан эрхийн шимтгэл, шан харамж төлөх үүрэг хүлээж эрхийн шимтгэл, шан харамж нь тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газарт бий болсон бол төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газрын оршиж байгаа Хэтэлцэн тохирогч Улсад эрхийн шимтгэл, шан харамж бий болсон гэж үзнэ.

6. Эрхийн шимтгэл, шан харамж төлөгч болон авах эрхийг жинхэнэ эгэмшигчдийн хооронд, мөн түүнчлэн гэдгэрийн болон гурандагч этгээдийн хооронд төгтоосон онцлог харилцааны улмаас шалтгаалан төлж буй эрхийн шимтгэл, шан харамжийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ эгэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс ямар ч шалтгаанаас хамаагүй хэтэрвэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хамгийн эцэст дурдсан хэмжээнэ хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан Хэтэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу

татвар ногдуулна.

7. Хэрэв энэхүү зүйлийн эрхийн шимтгэл, шан харамж төлөгдөх илүү талыг ашиглах зорилгоор аливаа этгээд нь гол зорилго буюу гол зорилгуудын нэг болгон өөрийн эрхийг бий болгосон буюу байршуулсан бол энэхүү зүйлийн заалтуудыг хэрэглэхгүй.

13 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгаа, энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлд хамаарах үл хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч этгээдийн дараах хөрөнгийг борлуулснаас олсон орлого Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно:

а/ Зөвшөөрөгдсөн хөрөнгийн биржид худалдаалагддаг хувьцаанаас бусад, Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг ихэнчлэн буюу бүхэлдээ үл хөдлөх хөрөнгөөс бүрддэг хувьцаа, буюу

б/ Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг хөрөнгө нь голчлон үл хөдлөх хөрөнгөөс бүрддэг партнершин /нөхөрлөл/ буюу траст дахь хүү, буюу Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг хөрөнгө нь голчлон дээр дурдсан а/хэсэгт дурдсан хувьцаанаас бүрддэг партнершин /нөхөрлөл/ буюу траст дахь хүү.

3. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх эд хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад мэргэжлийн бие даасан үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж байгаа товлосон газарт харьяалагдах хөдлөх эд хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого, мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар /дангаар буюу аж ахуйн нэгжийн хамт/ буюу ийм товлосон газрыг худалдаж борлуулснаас орох орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

4. Олон улсын шугамд Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн ашиглагдаж буй хөдөг онгоц, нисэх онгоц, төмөр болон хуурай замын тээврийн хэрэгсэл буюу эдгээр тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх эд хөрөнгийг Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч худалдаж борлуулснаас олсон орлогод зөвхөн тэр Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

5. Энэхүү зүйлийн 1, 2, 3 ба 4 дүгээр заалтад зааснаас бусад аливаа хөрөнгийг худалдан борлуулснаас орох орлогод зөвхөн уг хөрөнгийг худалдсан этгээдийн байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно, хэрэв уг орлого тэр Хэлэлцэн тохирогч Улсад татварт хамаарагдахаар байвал.

6. Энэхүү зүйлийн 5 дугаар заалт нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч хувь этгээд аливаа хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогод өөрийн хуулийн дагуу татвар ногдуулах Хэлэлцэн тохирогч Улсын эрхийг хөндөхгүй бөгөөд уг хөрөнгийг борлуулсны шууд дараагийн таван жилийн аливаа хугацаанд уг хувь этгээд нь эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч байсан байх нь дээр дурдсан нөхцөлийг

хэрэгжүүлэх үндэс болно.

14 дүгээр зүйл. Бие даасан хувийн үйл ажиллагаа

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бие даасан шинжтэй аливаа бусад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно. Гэхдээ уг орлогод дараах тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад мөн татвар ногдуулж болно:

а/ Хэрэв уг байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн үйл ажиллагаа явуулах үүднээс өөрийн товлосон газрыг байнга ашиглаж байвал, энэ тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад орлогын зөвхөн товлосон газарт хамаарагдах хэсэгт, буюу

б/ Уг байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршин суух хугацаа буюу оршин суух нийт хугацаа тухайн хуанлийн жилд 183 өдрөөс давбал, энэ тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад түүний явуулсан үйл ажиллагаанаас тэрхүү хуанлийн жилд олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "мэргэжлийн үйл ажиллагаа" гэж тухайлбал шинжлэх ухаан, уран зохиол, соёл урлаг, боловсрол болон багшлах чиглэлийн бие даасан үйл ажиллагаа, түүнчлэн эмч, өмгөөлөгч, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хэлнэ.

15 дугаар зүйл. Бие даасан бус хувийн үйл ажиллагаа

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин, хөлс болон түүнтэй адилтгах орлогод энэхүү Конвенцийн 16, 18, 19, 20 ба 21 дүгээр зүйлд заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байвал тэрхүү ажил үйлчилгээнээс олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж буй ажил үйлчилгээнээс олсон орлогод эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч Улсад дор дурдсан нөхцөлд татвар ногдуулна.

а/ Орлого авагч нь тухайн санхүүгийн жил эхэлж байгаа буюу дуусаж байгаа аливаа арванхоёр сард нийтдээ 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол, болон

б/ Орлогыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаггүй ажил олгогч өөрөө, эсвэл түүний нэрийн өмнөөс төлсөн бол, болон

в/ Орлогыг ажил олгогчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар буюу товлосон газар нь төлөөгүй бол.

3. Энэхүү зүйлийн түрүүчийн заалтуудыг үл харгалзан олон улсын шугамд тээвэр хийж буй хөлөг онгоц, нисэх онгоц, төмөр буюу хуурай замын тээврийн хэрэгслийн дотор хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсөнд хөлөг онгоц, нисэх онгоц, төмөр буюу хуурай замын тээврийн хэрэгслийг ажиллуулж буй аж ахуйн нэгжийн байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсад

татвар ногдуулж болно.

16 дугаар зүйл. Захирлуудын хөлс

Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь компанийн захирлуудын зөвлөлийн гишүүний буюу компаний түүнтэй адилтгах байгууллагын гишүүний хувьд авсан цалин болон түүнтэй адилтгах бусад төрлийн шагнал урамшуулалд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

17 дугаар зүйл. Урлагийн ажилтнууд ба тамирчид

1. Энэхүү Конвенцийн 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч театр, киноны жүжигчин, радио буюу телевизийн урлагийн ажилтан, хөгжимчин буюу тамирчны хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Энэхүү Конвенцийн 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан урлагийн ажилтан буюу тамирчны хувийн тоглолт хийж олсон орлого өөрт нь биш бусад этгээдэд ногдож байгаа тохиолдолд уг орлогод тоглолт болсон тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад явуулсан үйл ажиллагааг Хэлэлцэн тохирогч Улсуудын нэг нь буюу хоёр, эсвэл тэдгээрийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд бүхэлд нь буюу ихэвчлэн нийтийн сангаас гаргаж байвал, жүжигчин буюу тамирчнаас Хэлэлцэн тохирогч Улсад явуулж олсон үйл ажиллагааны орлогод жүжигчин буюу тамирчны байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

18 дугаар зүйл. Тэтгэвэр

1. Энэхүү Конвенцийн 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдийн урьд хийж байсан ажилтай нь холбоотой олгосон тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад төлбөр, болон тэрхүү байнга оршин суугч этгээдэд олгосон тодорхой хугацааны шагнал урамшилд зөвхөн тухайн Улсад татвар ногдуулна.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан тухайн Хэлэлцэн тохирогч Улсын нийгмийн хамгааллын системийн нэг хэсэг болох нийгмийн хамгааллын сангаас Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн олгож байгаа тэтгэвэр болон бусад төлбөрт тухайн Улсад татвар ногдуулна.

3. "Тодорхой хугацааны шагнал урамшил" гэж мөнгөөр буюу мөнгөөр илэрхийлэгдсэн эд зүйлсээр төлөөлүүлэн олгохоор хүлээн үүргийн дагуу үе үе тодорхой хугацаанд амьдралын нь турш тогтсон буюу тодорхой хугацаагаар хувь этгээдэд олгодог тогтмол төлбөр.

19 дүгээр зүйл. Засгийн газрын алба

1. а/ Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс тэр Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хаасны нь хувьд хувь этгээдэд төлж байгаа тэтгэвэрээс бусад шагнал урамшилд зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

б/ Энэхүү заалтын а/ хэсгийг үл харгалзан уг хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад алба хааж байгаа ба тэндхийн байнга оршин суугч бол тийм шагнал урамшилд зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна. Уг хувь этгээд нь:

1/ Нөгөө Улсын харьяат бол, буюу

2/ Гагцхүү алба хаах үүднээс нөгөө Улсын байнга оршин суугч болоогүй бол.

2. а/ Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хааж байсны хувьд хувь этгээдэд тэр Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сангаас төлсөн буюу олгосон аливаа тэтгэвэрт зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

б/ Энэхүү заалтын а/ хэсгийг үл харгалзан уг хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч бөгөөд тэр Улсын харьяат нь бол тийм тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хаасны хувьд олгосон шагнал урамшил ба тэтгэвэрт энэхүү Конвенцийн 15, 16, 17 ба 18 дугаар зүйлүүд хамаарна.

20 дугаар зүйл. Багш нар ба эрдэм шинжилгээний ажилтан

1. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсуудын аль нэгэнд их сургууль, коллеж, сургууль буюу бусад хүлээн зөвшөөрсөн боловсролын байгууллагад хичээл заах буюу шинжлэн судлах ажил хоёр жилээс илүүгүй хугацаагаар хийхээр ирсэн хувь этгээд нь ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан тохиолдолд уг хувь этгээдийн эхэнд дурдсан Улсад ирсэн өдрөөс хойш хоёр жилээс илүүгүй хугацаанд хичээл зааж, шинжилгээ судалгаа хийж олсон аливаа шагнал урамшилд зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна.

2. Энэхүү Конвенцийн заалтуудыг нөгөө Улсын хүчин төгөлдөр хуультай нэгтгэн үзэж энэхүү зүйлийн 1 дүгээр заалтад дурдсан багш буюу эрдэм шинжилгээний ажилтны шагнал урамшлыг нөгөө Улсад татвараас чөлөөлвөл, эсвэл нөгөө Улсад төлөх татварын хэмжээтэй тэнцүү шагнал урамшлыг хөнгөлвөл ийм шагнал урамшилд зөвхөн эхэнд дурдсан Улсад татвар ногдуулна.

3. Голчлон хувь хүн буюу хувь этгээдийн тусын тулд биш нийтийн ашиг сонирхлын тусын тулд хувь этгээдийн хийж байгаа шинжилгээ судалгааны орлогод энэхүү зүйлийн заалтууд хамаарна.

21 дүгээр зүйл. Оюутнууд

Хэлэлцэн тохирогч Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан буюу одоо хэвээр байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсад гагцхүү суралцах, боловсрол эзэмших зорилгоор ирсэн оюутан, ажлын дадал эзэмшигч буюу дадлага хийгчийн авч байгаа доорх төлбөрүүд нь эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч Улсад татвараас чөлөөлөгдөнө.

а/ өөрийгөө тэжээх, суралцах, судалгаа, эрдэм шинжилгээний ажил буюу дадлага хийхэд зориулан Хэлэлцэн тохирогч Улсын гадна эх үүсвэрээс авч байгаа тэтгэлэг, болон

б/ Аливаа санхүүгийн жилд Хэлэлцэн тохирогч Улсад хийж гүйцэтгэсэн хувийн үйлчилгээнээс 1500 фунт стерлинг буюу түүнтэй тэнцэх Монгол төгрөгөөс илүүгүй олсон орлого.

22 дугаар зүйл. Бусад орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн хаана ч бай жинхэнэ эзэмшдэг энэхүү Конвенцийн өмнөх зүйлүүдэд хөндөгдөөгүй траст буюу нас нөгчсөн этгээдийн зохицуулсан хөрөнгөөс төлөгдсөнөөс бусад орлогын төрлүүдэд зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

2. Хэрэв орлого ологч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраараа дамжуулан бизнес явуулж байгаа буюу тэнд байгаа товлосон газраар дамжуулан бие даасан мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уг орлоготой холбогдсон эрх ба эд хөрөнгө нь энэ төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд холбоотой бол энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогын хувьд энэхүү зүйлийн 1 дүгээр заалт үл хамаарна. Энэ тохиолдолд энэхүү Конвенцийн 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

3. Хэрэв энэхүү зүйлд дурдсан орлого төлөгч болон орлого авах эрхийг жинхэнэ эзэмшигчдийн хооронд, мөн түүнчлэн тэдгээрийн болон гуравдагч этгээдийн хооронд тогтоосон онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй төлбөрийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэжээнээс хэтэрч байвал, энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох эцэст дурдсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

4. Хэрэв энэхүү зүйлийн орлого төлөгдөх илүү талыг ашиглах зорилгоор аливаа этгээд нь гол зорилго буюу гол зорилгуудын нэг болгон өөрийн эрхийг бий болгосон буюу байршуулсан бол энэхүү зүйлийн заалтуудыг хэрэглэхгүй.

23 дугаар зүйл. Хөрөнгө

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн эзэмшиж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлд дурдсан үл хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдэж байгаа хөрөнгөнд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрлаж, түүний үйл ажиллагаанд ашиглагддаг хөрөнгийн зарим хэсгийг бүрдүүлэгч хөдлөх хөрөнгө буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харьяалагдах хөдлөх хөрөнгөд төлөөлөгчийн газар буюу товлосон газар байрладаг нөгөө Улсад татвар ногдуулж болно.

3. Олон улсын шугамд ашиглагдаж буй хөлөг онгоц, нисэх онгоц, төмөр буюу хуурай замын тээврийн хэрэгслээр илэрхийлэгдсэн хөрөнгө буюу эдгээр тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хамрагдах хөдлөх хөрөнгөд энэхүү Конвенцийн 8 дугаар зүйлийн дагуу ашигт нь татвар ногдуулах зөвхөн тэр Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

4. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн бусад төрлийн бүх хөрөнгөд зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

24 дүгээр зүйл. Давхар татвар ногдуулахгүй байх

1. Нэгдсэн Вант Улсын хуулийн заалтуудын дагуу Нэгдсэн Вант Улсын нутаг дэвсгэрийн гадна төлбөл зохих татварыг Нэгдсэн Вант Улсын татвараас хөнгөлөхдөө /энэ нь ерөнхий зарчмыг хөндөхгүйгээр/;

а/ Монгол Улсын эх үүсвэрээс олсон ашиг, орлого буюу хөрөнгө борлуулсны орлогод /дивидендийн хувьд дивиденд төлөөд үлдсэн ашигт ногдвол зохих татвар хамаарахгүй/ Монголын хуулийн дагуу Монгол Улсад төлбөл зохих татварыг шууд буюу хасалтын аргаар тэрхүү ашиг, орлого буюу хөрөнгө борлуулсны орлоготой холбогдуулан тооцсон Нэгдсэн Вант Улсын аливаа татвараас хасч болох бөгөөд энэ хасалтыг Монголын тооцсон татвартай холбож хийнэ;

б/ Нэгдсэн Вант Улсын байнга оршин суугч компанид Монгол Улсын байнга оршин суугч компаниас төлсөн дивидендийн хувьд дивиденд авагч компани нь дивиденд төлөгч компаний саналын 10-аас доошгүй хувийг шууд буюу шууд бусаар эзэмшиж байвал дивиденд төлсөн ашгийн хувьд компаний Монголд төлбөл зохих татварыг /үүнийг зэрэгцээ энэхүү зүйлийн а/ хэсгийн дагуу Монголын хөнгөлөлтөд хамаарагдах аливаа татварыг оролцуулан/ хөнгөлөлтөд хамааруулна.

2. Монгол Улсын байнга оршин суугч нь Нэгдсэн Вант Улсад орлого олж байвал энэхүү Конвенцийн дагуу уг орлогоос Нэгдсэн Вант Улсад төлбөл зохих татварын дүнг тухайн байнга оршин суугчид ногдуулах Монголын татвараас хасч тооцно. Гэхдээ хөнгөлөлтийн дүн нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу тухайн орлогод ногдуулсан Монголын татварын хэмжээнээс хэтрэхгүй байна.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг ойлгохдоо энэхүү Конвенцийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болох ашиг, орлого буюу хөрөнгө борлуулсны орлогыг Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эзэмшиж байвал уг ашиг, орлого буюу хөрөнгө борлуулсны орлогыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын эх үүсвэрээс бий болсон гэж үзнэ.

4. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг ойлгохдоо "Монголд төлбөл зохих татвар" гэдэгт аливаа жилд төлбөл зохих Монголын татварын хэмжээ болон Монголын хуулийн дараагийн заалтуудыг хэрэглэснээр тэр жил буюу тэр жилийн аливаа хэсэгт татварыг бууруулсан хөнгөлөлтийг оруулж тооцно:

а/ Энэхүү конвенцид гарын үсэг зурсан өдрөөс хойш засвар оруулаагүй буюу ерөнхий зарчмыг хөндөхгүй бага зэрэг засвар оруулсан тохиолдолд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын 1/ хэсэг, буюу

б/ Тохирсноос хойш засвар оруулаагүй буюу ерөнхий зарчмыг хөндөхгүй бага зэрэг засвар оруулсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч

Улсуудын эрх бүхий байгууллагуудын хооронд хойшид тохирох татварыг бууруулах хөнгөлөлтийн талаарх аливаа адилтгах бусад заалт.

5. Энэхүү зүйлийн 4 дүгээр заалтын дагуу Нэгдсэн Вант Улсын татвараас хөнгөлөхдөө энэхүү заалтад дурдсан нөхцөлүүдээр татварыг бууруулсан хөнгөлөлт буюу чөлөөлөлтийг энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш бий болсон буюу хуримтлагдсан ашиг, орлого буюу хөрөнгө борлуулсны орлогод төлбөл зохих татварын хувьд 10 жилээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ.

6. Хэлэлцэн тохирогч Улсууд хоорондоо хэлэлцээр байгуулж энэхүү зүйлийн 5 дугаар заалтад дурдсан хугацааг сунгаж болно.

25 дугаар зүйл. Хөнгөлөлтийн хязгаарлалт

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын хүчин төгөлдөр хуулийн дагуу тухайн этгээдийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсаас олсон нийт орлогын хувьд биш, харин тэнд авсан буюу шилжүүлсэн орлогод татвар ногдуулах бөгөөд Энэхүү Конвенцийн аливаа заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсад аливаа орлогыг татвараас хөнгөлөхөөр байвал Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулсан зөвхөн тэрхүү татварын хэмжээтэй тэнцүү хэмжээнд энэхүү Конвенцийн дагуу Хэлэлцэн тохирогч Улсад хөнгөлөлтийг хэрэглэнэ.

2. Энэхүү Конвенцийн аливаа бусад зүйлийн заалтуудыг үл харгалзан гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих урамшуудын талаарх дотоодын хуулийн дагуу Хэлэлцэн тохирогч Улсад орлого буюу хөрөнгө борлуулсны орлогод татвар төлөөгүй буюу бууруулсан хувь хэмжээгээр татвар төлсөн Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч буюу энэхүү байнга оршин суугчтай холбоо бүхий этгээд нь энэхүү Конвенцийг ашиглаж өөртөө ашиг олохыг гол зорилгоо буюу гол зорилгын нэг болгосон байвал энэхүү Конвенцид тусгагдсан Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад олгодог татварын аливаа хөнгөлөлт буюу чөлөөлөлтийг эдлэхгүй.

26 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхах явдал гаргахгүй байх

1. Хэлэлцэн тохирогч Улсын харьяатын Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар төлөх болон түүнтэй холбоотой бусад шаардлага, ялангуяа байнга оршин суудаг газрын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харьяатыхтай адил нөхцөлд Хэлэлцэн тохирогч Улсын харьяатыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харьяатаас татварын адилгүй буюу илүү хүндрэлтэй байдалд оруулахгүй.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газрын татвар төлөх нөхцөлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад түүнтэй адилтгах төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцөлөөс дор байлгаж болохгүй.

3. Энэхүү Конвенцийн 9 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт, 11 дүгээр зүйлийн 7 буюу 10 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 6 буюу 7 дугаар заалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох ашгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй хүү /11 зүйлийн 8 дугаар заалтад хамаарагдах хүүг оролцуулан/, эрхийн шимтгэл, шан харамж болон бусад төлбөрийг эхэнд дурдсан Улсын байнга оршин суугч этгээдэд төлсөнтэй адил нөхцлөөр хасна.



4. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд бусаар бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн өмчлөх буюу хянаж байвал Хэлэлцэн тохирогч Улс өөрийн адил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх буюу түүнтэй холбоотой шаардлагаас өөр буюу илүү хүндрэлтэй байдалд оруулах хариуцлага ногдуулахгүй.

5. Энэхүү зүйлийг аль ч Хэлэлцэн тохирогч Улс нь өөрийн байнга оршин суугч биш хувь этгээдэд өөрийн харьяат буюу байнга оршин суугч этгээдэд үзүүлдэг хувь этгээдийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон багасгалтыг хэрэглэх эрх эдлүүлэх ёстой гэсэн утгаар хэрэглэхгүй.

6. Энэхүү зүйлийн заалтууд нь энэхүү Конвенцид хамаарагдах татваруудад хамаарна.

27 дугаар зүйл. Харилцан тохирох журам

1. Хэрэв аливаа этгээд Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад энэхүү Конвенцид заагдаагүй татвар түүнд ногдуулсан буюу ногдуулах боллоо гэж үзвэл тухайн улсын хууль тогтоомжийн нэмэлт заалтуудыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улс буюу /хэрэв түүнд 26 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг хэрэглэвэл/ харьяат Улсынхаа эрх бүхий байгууллагад гомдлоо гаргаж болно.

2. Гаргасан гомдол нь үнэний хувьтай бөгөөд нэг нь гомдлыг нотолж хангалттай шийдвэр гаргах боломжгүй бол түүний эрх бүхий байгууллага энэхүү Конвенцид заагдаагүй татвараас зайлсхийх явдал гаргуулахгүй байх үүднээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын эрх бүхий байгууллагатай уг гомдлыг харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэтэнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Конвенцийг хэрэглэх болон тайлбарлахад үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлтээтэй асуудлуудыг харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэтэнэ.

4. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өмнөх заалтуудад дурдсаны дагуу тохиролцоонд хүрэх зорилгоор өөр хоорондоо шууд харилцаж болно.

28 дугаар зүйл. Харилцан мэдээлэл солилцох

1. Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Конвенцид хамрагдах заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс, энэхүү Конвенциор зохицуулагдах татваруудын тухай Хэлэлцэн тохирогч Улсуудын дотоодын хууль тогтоомжуудын талаар, энэхүү Конвенцид харш бус шаардлагатай мэдээллийг харилцан солилцоно. Татвар ногдуулах явдал нь энэхүү Конвенцид харшлахгүй байхын зэрэгцээ хуурч мэхлэхээс урьдчилан сэргийлж, хуулийн цоорхойг ашиглан татвараас зайлсхийх явдлын эсрэг хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэхэд чиглэсэн байх ёстой. Хэлэлцэн тохирогч Улс хүлээн авсан мэдээллийг өөрийн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу авах мэдээллийн нэгэн адил нууцалж, зөвхөн энэхүү Конвенцид хамаарагдах татварын хэмжээг тогтоох буюу хураах, албадан хураах буюу шүүхийн шийдвэр гаргах, маргаан таслахтай холбогдол бүхий этгээдүүд, эрх барих байгууллагуудад /түүний дотор шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан/ мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд, эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн дээрх зорилгод ашиглана. Түүнчлэн тэд дээрх мэдээллийг олон нийтийн шүүх ажиллагааны явцад задлах буюу



шүүхийн шийдвэрт тусгаж болно.

2. Дээрх заалт нь ямар ч тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсад дараах үүргийг хүлээлгэх ёсгүй:

а/ Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны арга хэмжээ авах,

б/ Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж болон захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээллээр хангах.

в/ Аливаа худалдаа, бизнес, үйлдвэр, арилжаа буюу мэргэжлийн нууц буюу худалдааны үйл ажиллагааг илрүүлэх мэдээ болон нийгмийн хэв журамд харшлах мэдээллээр хангах.

29 дүгээр зүйл. Дипломат буюу байнгын төлөөлөгчийн газар ба консулын газрын гишүүд

Энэхүү Конвенцийн заалтууд нь олон улсын эрх зүйн түгээмэл хэм хэмжээ болон тусгай хэлэлцээрийн заалтуудын дагуу дипломат буюу байнгын төлөөлөгчийн газар буюу консулын газрын гишүүдийн санхүүгийн хөнгөлөлт эдлэх эрхийг үл хөндөнө.

30 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох тухай

Хэлэлцэн тохирогч Улс бүр уг Конвенцийг дотоодын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр болгон баталсанаа дипломат шугамаар нөгөө талдаа нот бичгээр мэдэгдэнэ. Энэхүү Конвенц нь эцсийн нот бичиг солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, дараах хүрээг хамаарна:

а/ Нэгдсэн Вант Улсад:

1/ Уг Конвенц хүчин төгөлдөр болсон хуанлийн жилийн дараах жилийн 4 дүгээр сарын 6-ны өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилийн орлогын татвар болон хөрөнгө борлуулсны татварыг,

2/ Уг Конвенц хүчин төгөлдөр болсон хуанлийн жилийн дараах жилийн 4 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа санхүүгийн жилийн корпорацийн татварыг.

б/ Монгол Улсад:

1/ Уг Конвенц хүчин төгөлдөр болсон хуанлийн жилийн дараах жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүний дараагийн өдрөөс эх үүсвэрт нь суутгалаар төлсөн буюу хөнгөлсөн татварын хэмжээг.

2/ Уг Конвенц хүчин төгөлдөр болсон хуанлийн жилийн дараах жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилийн бусад татварыг.

31 дүгээр зүйл. Дуусгавар болох хугацаа

Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч Улсуудын аль нэг нь цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Хэлэлцэн тохирогч аль нэг Улс нь уг Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 5 дахь жилийн дараах хуанлийн жил



дуусахаас наанадаж 6 сарын өмнө дипломат шугамаар нот бичгээр цуцлах тухайгаа мэдэгдэж болно. Энэ тохиолдолд уг Конвенц дараах хүрээнд үйлчлэхээ болино.

а/ Монгол Улсад:

1/ Нот бичиг өгсөн хуанлийн жилийн дараахь жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүний дараагийн өдрөөс эх үүсвэрт нь суутгалаар төлсөн буюу хөнгөлсөн татварт.

2/ Нот бичиг өгсөн хуанлийн жилийн дараах жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилийн бусад татварт.

б/ Нэгдсэн Вант Улсад:

1/ Нот бичиг өгсөн хуанлийн жилийн дараах жилийн 4 дүгээр сарын 6-ны өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилийн орлогыг татвар болон хөрөнгө борлуулсны татварт.

2/ Нот бичиг өгсөн хуанлийн жилийн дараах жилийн 4 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа санхүүгийн жилийн корпорацийн татварт.

Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

Энэхүү Конвенцийг *Лондон* хотноо 1996 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр монгол, англи хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН
НЭГДСЭН ВАНТ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ